

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
МОНГОЛ ХЭЛ СОЁЛЫН СУРГУУЛЬ
эрдэм шинжилгээний бичиг

Tom. XXXV (367)

2012

(73-81)

МОНГОЛЖСОН (ХАРЬ) ҮГИЙН БИЧЛЭГИЙГ
ЖУРАМЛАХ АСУУДАЛД

Ч. Баттулга *

“Монголчууд эрт цагаас дэлхийн олон оронтой холбоо харилцаатай явж ирсэн учраас тэдгээр улсын хэлнээс монгол хэлэнд олон арван үг орж, үгийн сан нь улам бүр баяжсаар ирсэн байна. Одоо монгол хэлэнд дэлхийн 30 орчим хэлний үг байна.”¹

“Хэл шинжлэлийн үүднээс хэл бүр харилцахын хэрэглүүр болж чаддагийн хувьд орчуулж болдоггүй үг гэж байдаггүй, харин тухайн орчуулагчийн хэр хэмжээнээс шалтгаалан орчуулж чадах чадахгүй явдал буй.”² ч нэгэнт орчуулалгүй нийтээр хэрэглээд хэвшчихсэн үгсийг буцаан орчуулж хэрэглэнэ гэдэг төвөгтэй юм. Харин тэдгээр үгийг яаж бичиж тэмдэглэх вэ? гэдэг асуудал нэн тулгамдуу байна. Тухайлбал: Орос хэлний *плитка* гэдэг үгийг *нэлээтэг* (*нилээтэг*) гэж хэлж яриад хэвшчихсэн хирнээ одоо хүртэл яаж бичиж тэмдэглэхийг нэг мөр шийдээгүй байна.

Энэ талаар анх академич Ц.Дамдинсүрэн: *Бид одоо гадаадаас авсан үгийг маш олон янзаар бичин, уншигчдыг хаширааж байна. Жишээлбэл: газрын тосыг “Үнэн” сонинд яаж бичигдсэнийг үзвэл, 1931 оны 91 дүгээрт **невти** мөн оны 229 дүгээрт **нейвти**, 1932 оны 15 дугаарт **найвдай**, мөн оны 219 дүгээрт **нивди** гэж бичсэн байна. (Үүнийг)...нэг дүрэмтэй болговол зохино. Нэг дүрэмтэй болгохдоо бид **тэр газрын бичдэг үсгийг баримтлах уу? Хэлдэг дууг баримтлах уу? Мөн монгол аялгуунд тааруулах уу? Үгүй юү? Бас дэлхий дахины олонхи хэлийг баримтлах уу?** гэх зэргийн олон асуулт гарч ихээхэн зөрөлдөөн байгаа тул хувьд бодвол **тэр газрын хэлдэг дууг гол болгож монгол аялгуунд нийцүүлэхийг хичээн**, эцэсдээ гадаадаас авсан үг, жинхэнэ монгол үг гэж хоёр тэс ондоон дүрэмтэй болохгүй тийм зорилгоо тавьж явуулбал зүйтэй болов уу гэж санана*³. хэмээсэн байна.

Мөн А.Лувсандэндэв 1959 онд бичсэн “Гадаад үгийг хэрхэн бичих тухай асуудалд” өгүүлэлдээ: “Монгол хэлэнд бүрмөсөн шингээгүй, харь хэлний үг гэж мэдэгдэж байгаа боловч уг авианы бүрэлдэхүүнээ оорчлон монгол хэлний авиан зүйн онцлогийг дагаж

* МУИС-ийн МХСС-ийн Монгол хэлний тэнхим

¹ Н.Балжинням, *Монгол хэлний хятад ормол үгийн судалгаа*, Улаанбаатар, 2009, 4-р тал

² Ц.Шагдарсүрэн, *Эх хэлээ эвдэхгүй юм сан*, Улаанбаатар, 2010, 116-р тал

³ Ц.Дамдинсүрэн, *Хичээл билгээ гаргаж хэл бичгээ хөгжүүлбэ*, Монгол хэл бичгийн тухай, Улаанбаатар, 1957, 103-р тал

монгол үг мэт дуудагдах болсон өдөр тутмын аж байдалтай холбогдол бүхий юмны нэрсийг дуудлагаараа бичвэл зүйтэй гэж үзэж байна. Жишээлбэл:

1. Маасал	ор.масло	
2. Лаамп-лаампаг	ор.лампа	
3. Биржээх	ор.брезент	гол.pressening
4. Бүрш	ор.ружина	
5. Боошиг	ор.бочка	
6. Голоош	ор.галоши	фр.galoches
7. Пальтоо	ор.пальто	фр.paletot
8. Косчүүм	ор.костюм	фр.costume
9. Саахар	ор.сахар	перс.sakar гэх мэт.

Аж байдалтай холбогдолтой үгсээс гадна хөдөө аж ахуй, техник, соёлын ба бас бус зарим нэр томъёог мөн дуудлагаараа бичиж болох юм. Жишээлбэл:

1. Овьёос	ор.овёс	
2. Мирнуус	ор.меринос	исп.merinos
3. Тооромсог-тоормос	ор.тормоз	грек.tormos
4. Эрээнгэ	ор.резина	лат.resina
5. Хаминдаа	ор.комендант	фр.commandant
6. Аагинт	ор.агент	лат.agens
7. Вогоон	ор.вагон	англ.wagon
8. Завууд	ор.завод	
9. Машийн	ор.машина	лат.machine
10. Тараактор	ор.трактор	лат.troho
11. Гоожин	ор.козин	
12. Ноором	ор.норма	лат.norma
13. Хонтоор	ор.контора	грек.kontor
14. Гарааш	ор.гараж	фр.garage
15. Билээд	ор.билет	фр.billet
16. Жижүүр	ор.дежурный	фр.de jour" хэмээн

өдөр тутмын аж байдалтай холбогдол бүхий юмны нэрсийг дуудлагаараа бичвэл зүйтэй гээд, цөөнгүй жишээ үзүүлжээ⁴.

Г. Аким "Гадаад үг нэвтрэхийг хязгаарлах хэрэгтэй гэсэн маань гадаад үгийг огт хэрэглэхгүй байх хэрэгтэй гэсэн үг огт бус аа. Олон улсын харилцаа өргөжиж мэдээлэл солилцох нь ихсэж байгаа одоо үед гадаад нэр томъёо хэлэнд нэвтрэх зүй ёсны үйл явцыг хэн ч зогсоож чадахгүй юм. **Гадаад үгийг авахад авна. Харин яаж авах вэ? Бичлэгээр нь авах уу, эсвэл өөрийн авианы зүйд нийцүүлэн авах уу?** Социализм, коммунизм, империализм зэрэг улс төрийн үгийг бичлэгээр нь авах нь зүйтэй гэдэг нь мэдээжийн юм. **Харин аж байдлын үгсийг бол монгол хэлний авиа зүйд зохицуулан авахад таарах мэт бодогдоно.** Жишээлэхэд, бааз, жижүүр, гарааш гэж одоо бичиж дуудаж байна. Аль ч хэл гадаад үгийг авахдаа өөрийн авиан зүйд уул үгийг зохицуулдаг

⁴ А.Лувсандэндэв, *Гадаад үгийг хэрхэн бичих тухай асуудалд*, 303-312, Монгол үндэсний утга зохиолын хэл бүрэлдэн тогтсон нь, 2002, Улаанбаатар

учиртай тул дээрх нь зүй ёсны юм. Жишээлбэл, орос хэлэнд ард, дээл, бууз, зэрэг монгол үгсийг арат, дэли, боз гэж бичдэг, монгол нэрийг ч орос дуудлагатай (Баянмөнх-Байнмунк, Сүхбаатар- Сухэ-Батор) болгон бичдэг шүү дээ. Иймээс аж байдлын холбогдолтой гадаад үгийг гарцаагүй хэвээр нь авах болбол **монгол хэлнийхээ дуудлаганд зохицуулан хэрэглэж байвал яасан юм бэ?** Бид хунт, фунт гэдэг үгсийг бичлэгээр нь авч хэрэглэдэг. Гэтэл дуудахдаа дуудлагаар нь дуудаж байна. Үүнээс болоод бичигт зохицохгүй юм гарч байгаа бөгөөд хунт бичсэн атлаа хүнт гэж дуудаж байгаагаа дагуулан уул эр үгэнд эм үгийн –ийн залгах уу, дуудлагыг нь баримталж –аар залгах уу, дуудлагыг нь баримталж –ээр залгах уу? Хэвлэлүүдэд фунтээр гэж бичсэн нь дайралдаж байна. Эр, эм үгийн дагавар, эгийг зохицох ёс гээд монгол хэлний зөв бичгийн дүрэм маань зөрчигдөхөд хүрч байна аа даа. Ингэхлээр эдгээр үгийг дуудлагаар нь авч хэрэглэвэл яасан юм бэ?”⁵ гэсэн бол, доктор М.Саруул-Эрдэнэ “Аливаа систем хөгжин дэвжих, ядаж оршин тогтнож байхын тулд өөрийгээ хамгаалах тогтолцоотой байх хэрэгтэй...Огт агааргүй бол гал асахгүй, гэтэл их салхи галыг унтрааж орхино. Яг үүний адилаар аливаа хэл бусад хэлтэй огт харилцахгүй “битүү” байвал ядуурч мөхөх замдаа орох бол ирсэн үг бүрийг өвөр хормой дэлгэн угтах аваас харийн хэлэнд эрлийзжсэх аюулд учирна. Ийм учраас хэлнүүд харь үгийг авахдаа “өөриймсүүлдэг”⁶ гэжээ”⁶ гээд паравоз-бярвааз, замок (бууны)– замаг, бочка- поошиг гэх мэт цөөнгүй жишээ дурьджээ.

Б.Пүрэв-Очир: Орос хэлний “хватить” гэдэг үйл үгийг монгол хэлний үг, авианы дуудлага, зохицолд нийцүүлэн, хялбаршуулж, **“хаваасаг”** гэж өөрчлөн хэлэх, хэрэглэхэд бас ч ер буруу юм байхгүй. Ер, монгол хэлний авианы дуудлагад нийцүүлэн “нутагшуулан авсан” харь үг – жижүүр, тараактар, данхраад, тооромсог, чагнаал, жүүс, бэртлээт, хотел, таавчиг, лээвчиг, хийсвэр (хийх), дойлуур, жийнс, пээнс, наар, баар зэрэг маш олон бий... Тэгэхлээр энэ үгийг “Пий. Ар” гэж бичиж дуудах нь зөв боловч, монгол хэлэнд **“ниар”** гэсэн богино хэлбэрээр хэлж, дуудаж нутагшуулах, хэрэглэх хандлага байгааг үгүйсгэх арга алга. Харин нөгөө “няр” нь юу л бол?! Ерөөсөө **“шаг”, “түц”, “дох”, “ану”, “сану”, “сөх”** г.м. товчилсон үгсээс шинэ нэрлэлт бүтээж, үгийн сан баяжсдаг ёсон байдаг. Тэгэхлээр **“ниар”** эсвэл **“ний. ар”** гэж хэвших боломж байгаа гэсэн үг юм. Чухам яаж хэвшихийг ард нийтийн хэлний хэрэглээ, дархлаа, цаг хугацааны өөрчлөлт харуулна. Эсвэл утга нь тохирсон монгол үгээр оноон тохоож, нэртомъёо болгон хэвшүүлэх учиртай юм. **Тухайн хэлний авианы хууль, үгийн бүтцийн ерөнхий жам ёсонд нийцүүлэн нутагшуулаад, хэвшүүлчихдэг нэг арга ч байгаа юм**⁷ гэжээ.

Д.Цэнддоо “Хуучин орос хэлтэй улсын эзэлсэн жинг өнөөдөр англи хэлтнүүд эзлэх болов. Үүнээс үүдээд шинэ үгийнхэн “нэлээтэг”-ийг яагаад “плитка” гэж бичээд байгаагийн учрыг асуухад “Оросоор тэгдэг” гэж хариулахад арай дутуу дулим болоод

⁵ Г.Аким, *Нэр томъёо орчуулах асуудалд*, Орчуулах эрдэм, УБ, 1986, 8-р тал

⁶ М.Саруул-Эрдэнэ, *Эх хэлний өөрийгээ хамгаалах тогтолцоо*, Сонирхолтой хэлшинжлэл, Блүүмингтон, 2006, 26-29 тал

⁷ Б.Пүрэв-Очир, *Монгол хэлний “янцаон үнэр”-ээс “яндашигүй”-г хүртэл хэдэн үг хэллэгийг сонирхон судалбал...*, Монгол хэлний бүтэц, утга, үүрэг, хэрэглээ-6, УБ, 2007, 256-257 тал

байна. Учир иймд нэгэнт монгол хэлэнд баттай орж, ойлголт бууцлагаараа манайшсан үгсийг монгол маягаар бичиж эхэлбэл яасан юм бэ гэсэн саналыг сэтгүүлч, зохиолч, туурвигч нартаа хандаж тавих гэсэн юм аа. Төмөр, дарь, архи, цонх, цүнх, харандаа, дэвтэр, ном, замаг, хаминдаа, жишжүүр, гарааш, чагнаал гээд олон арван өргөмөл үгийг цаад эх хэлэндээ хэрхэн бичдэгийг тэр бүр мэддэггүй, сонирхдоггүй. Та бүхэн монгол хэлний тайлбар толийн К, Р, Ф-ээр эхэлсэн үгсийг байг гэхэд Л толгойтой хэсгийг хараарай. Бидэнд төрсөн хүүхдээс ялгаагүй болсон өргөмөл үгс дүүрэн байна. Ингээд та бүхэндээ монгол үгээ монголоор бичих санал тавьж санаад орсон хэдэн жишээг хавсаргая. (Жишээг хавсралт 1-ээс үзнэ үү)⁸

Харь үгийг өөрийн хэлний авианы хууль, үгийн бүтцийн ерөнхий жам ёсонд нийцүүлэн нутагшуулаад, хэвшүүлчихдэг арга (Б.Пүрэв-Очир) аль ч хэлэнд байдаг, угаас хэлний өөрийгээ хамгаалах тогтолцоотой (М.Саруул-Эрдэнэ) холбоотой үзэгдэл болох нь тодорхой байна. Тухайлбал: Монгол хэлэнд орсон гадаадын олон хэлний үгсийн дотор манай урд их хөршийн хэл хятад хэлнээс орж идээшсэн олон монгол үг үгийн санд тодорхой байрыг эзэлж, төрөлх хэлний үгээс дутуугүй хэрэглээтэй болсон байна⁹.

Жишээ нь:

1. Байхуу (bǎihuā) - цагаан цэцэг
2. Байцаа (bǎiciǎ) - цагаан ногоо
3. Ганжин (gǎnmiánzháng) - нухсан гурил нимгэлэх бөөрөнхий мод, гурилын мод
4. Ганпанз (gǎnbānzi) - нухсан гурил элдэх хавтгай мод, гурилын мод
5. Лаа (lá) - гэрэл гаргахад зориулсан зүйл
6. Чүдэнз (qūdēngzi) - нарийн модны үзүүрт фосфорт хүхэрийн бодасыг наалдуулж хийсэн гал үүсгэх юм
7. Санхүү (cǎiūngkǔ) - хадгалах юмыг агуулсан гэр байшин, мөнгөн санхүү
8. Сийлүү (siliū) - даалууны арван нүдтэй нь
9. Үүлүү (wūliū) - даалууны арван нэгэн нүдтэй нь

“Иймэрхүү өргөн хэрэглэгдэх үгс илтгэж байгаа ухагдахууныхаа хамт сүүлийн үед тухайлбал хувьсгалаас хойш орж ирсэн учраас гадны үг гэдэг нь монгол хүний ухамсарт мартагдаагүй хэвээр үлдсэн байна. Бусад талаар ном, дэвтэр, байшин гэх мэтийн үгээс төдий л ялгагдахгүй болжээ. Бид ном гэхийг номос /грек nomos/, ертөнц гэхийг хжиг-ртен /төвд hjigs/, байшин гэхийг пишиван пиш-эйван /перс/, дуран гэхийг дур-бин /перс/, цонх гэхийг чуан-ху, бэртэгчин гэхийг пртхагжана /санс.prthagjana/, саван гэхийг савон /фр.savon/, гоожин гэхийг Козин гэж бичихгүй нь мэдээжийн хэрэг. Ийнхүү энэ хоёр бүлэг үгсийн хооронд ямар ч ялгаа /бидний өгүүлж байгаа талаар/ байхгүй болохоор өөрийн уугуул хэлний үгсийн адил энэтхэг, хятад, уйгур зэрэг хэлнээс урьд орж ирсэн үгсийн адил өөрийн өгүүлэх дуудлагыг баримтлан бичих нь зүйтэй мэт санагдана.”¹⁰ Уг уламжлалаар одоо ч нутагшин идээшиж байгаа (манайшиж,

⁸ Б.Цэнддоо, *Монгол үгээ монголоор бичих үү. Яах уу?*, Монгол хэлбичиг, VIII боть, УБ, 2009, 162-163 тал

⁹ Н.Балжинням, *Монгол хэлний хятад ормол үгийн судалгаа*, УБ, 2011, 4-р тал

¹⁰ А.Лувсандэндэв, *Гадаад үгийг хэрхэн бичих тухай асуудалд*, 303-312, Монгол үндэсний утга зохиолын хэл бүрэлдэн тогтсон нь, 2002, Улаанбаатар

өөриймсөн) үгсийг нэн даруй бүртгэн, бичих журмыг тогтоох нь хэлний экологийн нэн тулгамдсан асуудал юм. Монгол хүн орос хэлний “плитка” гэдэг үгийг дуудаж чадахгүйдээ “пилээтэг”, “пэлээтэг” гээд байгаа юм биш, харин монгол хэлний үгийн болоод үеийн бүтэц¹¹, тогтолцоогоо харь хэлээс хамгаалж, дархлааг тогтоож буй явдал юм¹².

Мөн нэг үгийг хэдэн янзаар бичдэг явдал цэгцлэгдэн, уншигч бичигчийг хашраах явдал үгүй болно. Үүнийг хэлний мэргэжилтэн бид, холбогдох яам, тамгын газартай хамтран шийдвэрлэнэ. Ийм журам стандартыг батлан гаргаж, толилох нь зүйтэй. Жишээ нь: Тантай Улаанбаатар хотын хаа сайгүй таарах “гараж, гарааж, граж, гарааш” гэх үгс цэгцлэгдэн, зөвхөн “гарааш” гэж бичиж тэмдэглэж хэвшинэ гэсэн үг. Монгол хэл суралцагч гадныхны хувьд ч бас нэгэн бэрхшээлээс ангижирна.

Харамсалтай нь, өнгөрсөн 50 жилийн хугацаанд (Ц.Дамдинсүрэн гуайн бичсэнээс одоо хүртэл) цэгцлэгдээгүй ирсэн нь “пэлээтэг, араажав, хөлөөв...” гээд хэлчихвэл гадаад хэл мэддэггүй “соёлгүй” хүн болчихно гэсэн нэрэлхүү зан, мөн харийнхан болон ихэс дээдэст зусардан бялдуучлахын хар гайгаар, хэлний аливаа үзэгдлийг эх хэлний зүй тогтолд бус харийн эрхмүүдийн таалалд хүчээр нийцүүлж ирсэн “гажиг” одоо ч арилахгүй байна.

Тэгвэл одоо ардчилсан, тусгаар тогтносон Монгол улсын эрдэмтэн судлаачид бид гадныханд зусардах, айж мэгдэх ямар нэг шалтгаан үгүй тул “тэдэнд зориулсан” зүйл хийхээ бүрмөсөн болих, “гадныхан юу гэх юм, гадныхан уншина, гадныхан мундаг, гадны эрдэмтнээс заавал иш татах ёстой” гэсэн гаж сэтгэлгээнээсээ салах хэрэгтэй.

2011 оны 10 сарын 05-ны өдрийн “Кирил бичгийн бичлэгийн стандарт тогтоох тухай” БСШУЯ-ны сайдын №1 тоот тушаал гарсан нь цаг үеэ олсон (гэхдээ үнэхээр), чухал зүйл болсон хэдий ч зарим нэг нягтлууштай зүйлүүд байгаа нь асуудалд арай хөнгөн гоомой хандчихав уу даа гэж бодсоноо нуух юун.

Ялангуяа, Гадаад үгсийн (Хавсралт 3) бичлэгийг нэг мөр болгохдоо ямар зарчимд суурилсан нь тодорхой бус (essay-ийг эсээ, garage-ийг гарааш, dommekracht-ийг данхраад гэснийг үзвэл дуудлагад суурилсан мэт) ерөнхийд нь тухайн хэлний бичлэгт нийцүүлсэн шинжтэй байна. Харин тухайн үгийн зөв дуудлагыг оноож өгсөн нь маш сайн хэрэг бөгөөд бид тэр дуудлагаар нь буюу тухайн хэлний зөв дуудлагад нь үндэслэн **Сүүл** гэдгийг **Сүүл** гэж дуудаж бичиж хэвшсэн шигээ л бичиж тэмдэглэе гэсэн саналыг дэвшүүлээд байгаа юм. Тэгвээс монгол хэлний нөхцөл дагаврыг залгахад ч ямар ч асуудалгүй болох юм. Тухайлбал: *эсээгээ бичээрэй, гараашны хаалга, данхраадаа аваад ир.* “Монгол хэл бичгийн эрдэмтэн судлаачид сонин сэтгүүл, радио телевиз, хэвлэл мэдээллийн хэл найруулгыг маш их ярьдаг, судалдаг. Гэтэл дээрх бүх хэрэгслээс хамаагүй илүү хүртээмжтэй, олон хүнд хүрдэг, идэвхтэй, хүчтэй газар авч

¹¹ “Орчин цагийн монгол хэлний үүсмэл биш үйл үгийн бараг дөрөвний нэг нь ГЭГ гэсэн авианы бүтэцтэй, байгаагаас үзвэл монгол үгийн язгуурын уламжлагдан ирсэн үндсэн бүтэц бололтой. ОЦМХ-нд Э, ЭГ, ГЭ, ГЭГ гэсэн бүтэцтэй язгуураас бусад ЭГЭ, ГЭГЭ, ГЭГЭГ, ЭГЭГ ... гэх мэт бүтэцтэй язгуурууд түүхэн үүднээс язгуур дагаарын нийлцээс үүссэн байна. Ц.Өнөрбаян, Орчин цагийн монгол хэлний үйл үг бүтэх ёс, УБ, 2000, 7-р тал.

¹² Тэгэхлээр, М.Саруул-Эрдэнэ докторын “Би олон хэлтэй хотын залуусаас илүү араажав (radio), хөлөөв (club) хэмээн хэлэлцэгч хөдөөний хөгшдийг “хэлний боловсролтой” гэмээр байдаг юм” гэсэнтэй бүрэн дүүрэн санал нийлж байна.

байгаа хэрэгсэл бол интернэтийн орчин юм. Одоо хэл шинжлэлийн чиглэлээр ажиллаж байгаа судлаачдын зайлшгүй анхааран үзэх судалгааны объект бол интернетийн орчны монгол хэлний өнөөгийн байдал юм. Ийм учраас интернэтийн орчин дахь монгол хэлний асуудлыг судлах нь монгол хэлшинжлэлийн хувьд шинэлэг хандлаг гэж хэлж болно.”¹³

Тэр ч байтугай "интернетийн хэл " (чаат, мээссэж, мээсэнжэр) гээч юм тогтож эхэлсэн байна. Үзэл бодлоо илэрхийлэх, мэдээллийг хир хурдан дамжуулах нь чухал болохоос ямар үсэг бичгээр тэмдэглэх, зөв бичгийн дүрмийн алдаатай эсэх нь чухал биш байна. Жишээ нь: Интернэт сонирхогч хэн бүхний мэдэх “нэрт” нийтлэлч Гаамп (Gump)-ын бичсэн нийтлэлүүд нь монгол бичгийн хэл, утга зохиолын хэлний хэм хэмжээг зөрчсөн, хүүхэд залууст этгээд, сонин үлгэр дууриал үзүүлж байна.

Сая нэг муу дураак яааваа. Гадамжинд шаал танихгүй дураак барьж авсанаа чам шиг хөдөөний хөөсөн мантуунуудаас болж хот маань муухай болжээн гэж авдаг гэнээ. Хуцжаагаа шүү хотод орж ирээд арав гаруй жил болоод шаал хотын хүн болчоод байхад. За тэрчлэху. Саяханаас энэ улс төрч, дарга марга хүмүүс дандаа гэр хорооллынхон утаа гаргаж байна, газраа зарж байр бариулахгүй байна гэж ярьдаг болж. Утаа гаргахгүй гээд хөлдөж үххүү дээ. Чадкуу за гээд хэлчмээр санагдаад байдаг болж. Бас байрад орхыг хүсэлгүй яахав дээ. Хамгийн ихээр хүсэж байгаа шүү дээ. Ямар сайндаа “Нэг насаар гэр хороололд байснаас Нэг өдөр байранд байсан нь дээр” гэж цаад гудамжинд чинь дуулж байна шүү дээ. Энд гэр хороололд байгаа бидний зовлонг дулаан байранд байгаа дарга нар ойлгохуу даа”¹⁴.

Энэ зүйлд яаж хандах талаар манай хэл судлаач эрдэмтэд ч үгээ хэлэх цаг болсныг дахин сануулъя.

Бичгийн хэлээ цэвэр ариун байлгах нь ёстой. Мэдээж бичгийн хэлэнд ярианы энэ мэт үзэгдлүүд нэвтрэх нь хэлний үгийн бүтэц, хэл зүйд нөлөөлж хэлийг эвдэхэд хүргэдэг бол монгол хэлний үгийн бүтэц, үг бүтэх ёс, эгшиг зохицох ёсонд үл тохирох харь үгсийг тэр чигээр нь бичигт тэмдэглэх мөн л тухайн хэлийг бохирдуулдаг байна.

Иймд юм бүхэн хоёр талтайн үлгэрээр Гаамп(Gump)-ын бичсэн бүх нийтлэлд (www.niitlech.gump.mn)-д харь үгийг хэрхэн монголчлон бичиж хэвшсэн, цаашид нийтээр ингээд биччихвэл яасан бэ гэсэн үгсийн жагсаалт гаргалаа. (Хавсралт 2). Мөн үүнийг нутагшсан идээшсэн харь үгийг монголчилж буй нийтлэлч Гаампын туршлага хэмээсэн ч болох юм.

Цаашид монгол хэлнээ идээшин дасаж буй үгсийн бичлэгийг журамлах бэсрэг толь бичиг гарган, улмаар бичлэгийн стандарт тогтоох зүйтэй. Ингэвээс уншигчдыг хашраахгүй. Үүнд, Профессор Н.Балжиннямын “...түүний ярианы хэлэндэх дуудлагын хэлбэрийг (яриа) хэмээн тэмдэглэж, *маарал, бакаал, жижүүр* гэж ...(Монгол хэлний гадаад үгийн толь, УБ, 2008, 5-р тал) бичсэн нь гол хэрэглэгдэхүүн болно.

¹³⁾ Д.Боролзой, *Интернэт монгол хэлний аюулгүй байдалд хэрхэн нөлөөлөх нь*, Хэл зохиол судлал, том.3(35), 2010, Fasc. 9.

¹⁴⁾ Гаамп (Gump), “Манайх наприйшиг түлдэг” нийтлэлээс, www.niitlech.gump.mn 2011 оны 9 сарын 5.

НОМ ЗҮЙ

1. Н.Балжинням (2008), *Монгол хэлний гадаад үгийн толь*, Улаанбаатар.
2. Н.Балжинням (2011), *Монгол хэлний хятад ормол үгийн судалгаа*, Улаанбаатар,
3. С.Бат-Эрдэнэ (2012), *Гадаад үгийн бичлэгийг нэг мөр болгосон тухай тэмдэглэл*, Монгол судлал, Боть XXXIV(360), Улаанбаатар, 340- 345-р тал.
4. Д.Боролзой (2010), *Интернэт монгол хэлний аюулгүй байдалд хэрхэн нөлөөлөх нь*, Хэл зохиол судлал, том.3 (35), Fasc 9.
5. Гаамп (Gump), *"Манайх наприйшиг түлдэг" нийтлэлээс*, www.niitlelch.gump.mn
6. Ц.Дамдинсүрэн (1957), *Монгол хэл бичгийн тухай*, Улаанбаатар.
7. Ч.Догсүрэн, *Монгол нэр томъёо оноох, толилох, жигдлэх асуудалд*, Улаанбаатар, 1988.
8. Орчуулах эрдэм (Эмхтгэсэн Н.Энхбаяр), Улаанбаатар, 1986
9. А.Лувсандэндэв (2002), *Монгол үндэсний утга зохиолын хэл бүрэлдэн тогтсон нь*, Улаанбаатар.
10. Д.Пүрэвдорж (2005), *Тулгын чулууг хөдөлгөж болохгүй*, Бор гэрийн Богд, Улаанбаатар, 140-150-р тал.
11. Б.Пүрэв-Очир (2007), *Монгол хэлний бүтэц, утга үүрэг, хэрэглээ-6*, Улаанбаатар.
12. Б.Цэнддоо (2009), *Монгол үгээ монголоор бичих үү. Яах уу?*, Монгол хэлбичиг, VIII боть, Улаанбаатар, 162-163-р тал.
13. М.Саруул-Эрдэнэ (2006), *Сонирхолтой хэлишинжлэл*, Блүүмингтон.
14. Ц.Өнөрбаян (2000), *Орчин цагийн монгол хэлний үйл үг бүтэх ёс*, Улаанбаатар.
15. Ц.Шагдарсүрэн (2010), *Эх хэлээ эвдэхгүй юм сан*, Улаанбаатар 116-р тал.

Хавсралт 1

1. Пэлээтэг- Гаазын пэлээтэг, микро пэлээтэг бараг тогтчихлоо
2. Хярлаа (Крыло буюу машины шаврын хаалтын эмжээр хэсэг. Эмээлийн хяр эн тэр гэдэг шиг сайхан монголжсон байна.)
3. Хунлятор (аккумулятор) \
4. Аржаатар (Аржийж барзайсан энэ юмыг радиотор гэхээ больё)
5. Амаржийнэ (машин тэргээр амар, зөөлөн явахад зориулсан хэрэгслэл буюу амартизатор)
6. Бажийнк (энийг заавал ботинка гээд яах ч билээ)
7. Больтоо (Пальто хэмээх дээл)
8. Юүпэг (миний юүпэг)\
9. Шэлээп (Ишляап гэдэггүй байж шляп гэж бичээд хэрэггүй)
10. Эрзээн (эрзээн мэт сунаад гэхээр зэхын эмгэн мэднэ)
11. Хаймар (дотуур хаймар, олгой хаймар)
12. Госчоом (госчоом пэнжээк өмсдөггүй монгол хүн алга. Энэ бол шинэ үеийн монгол үндэсний хувцас болно.)

13. Моод (энэ үгийг Мода гэхээр эвгүй Мод гэхээр ургамал гэж ойлгочих гээд зовлон их байдаг.)
14. Хээт (хээт бол монгол хүний өмсөх дуртай зүйл болж)
15. Пүүз (Найк пүүзтэй хүн ч хүн шиг харагддаг болж.)
16. Таагчиг (сонгуулийн таагчиг болж)
17. Арьзээтаг (арьзээтаггүй газар тог байгаад нэмэргүй)
18. Богоон (Богоон богоон цээмэнт хилээр орж ирж байна.)
19. Бүлтүүзэр (Сонсмоол машинд ачих шороог бүлтүүзэрээр түрж авчирдаг. Харин сэсчээрийн ёонкосонд шингэн ачаа ачдаг.)
20. Нармайлдах (Өвлийн цагт царцуу машиныг асаамагц арван минуут нармайлдах чухалтай.)
21. Авьтиирак (эрэг боолтыг түлхүүрээр, шүрүүнийг авьтииракаар эргүүлнэ.)
22. Хааз (Дарханы зам дээр хаазаа нэмээд давхина. Сагсуу нөхөр над руу баахан хаазалж байгаад явлаа.)
23. Тооромсог (энэ хэллэгийн хүрээ зөвхөн машинаар зогсохгүй. “Жолоогоо тат” гэдэг-хуучин хэллэгийн оронд “Хүүхээ, жаахан тоормогсогтой байгаарай” гэсэн хэллэг орж ирж байна.)
24. Манжаатаг (цамцны манжаатаг, Маньвийлддэг тэрэг унадаггүй, манжаатагтай дугуй тавьдаггүй жолооч оо би)... гэхчилэн энэ жагсаалтыг та бүхэн үргэлжлүүлээрэй.

Хавсралт 2

Автуус (атуус)	Граадуус	Кээт
Авжуур	Гүрүүшиг	Лээкц
Аквуурам	Грүүп	Маасаж
Апраад	Зожгоолок	Массааж (масааж)
Аптийк (аптээк)	Инплаац	Маарктинг
Баар	Интэрнээт	Маарт
Бакаал (бахиал)	Ирклаам	Мистер (мийстэр)
Байхуу	Ирстраан (Ирсдраан)	Мичнус
Бажийнк	Ирцедив	Мийс
Бацаан	Испийрт (испээрт)	Мидал (мидаал)
Бийзнэсмэн	Кампаани	Мийни юүпэг
Бидоон	Кандууктар	Мээсээж (мээсэж)
Боок	Каамэр	Мээсэнжэр
Браашиг	Кароокэ	Наастер
Бэнзээн (бинзээн)	Компүүтэр	Ноорм
Вогоон	Коомбий	Нээрв
Гимнаастиг	Конкуурс	Оочер
(гимнаасчиг)	Коопэ	Опцэр
Гонжоом	Куурчик (күүртик)	Парийк
Гоструул	Кээтчууп	Пааспарт

Паампэрс	Тиркоо
Паприйшиг	Трелайбус
Пиджаак	Тэнн
Пиав	Фраакц
Поошиг	Фроонт
Праактиг (праакчиг)	Чиклаадны крээм
Пүүдэр	Чимдаан
Пэчээн	Чокоопай
Пэлээтэг (пилээтэг)	Шампоон
Пэнгшүү	Шампаансаг
Сарпаан	Шоок
Синдроом	Шпаагээт
Симнаар	Электроон
Скэйт	Эмблээм
Сүүпэр	Юүпэг
Сээгс (сээкс)	
Таактиг(таакчиг)	

SUMMARY

As the Mongols have a long history of interaction with other peoples and nations, the Mongolian language has absorbed and been enriched by many dozens of words from foreign languages. Currently the Mongolian language contains words derived from approximately 30 other languages.

From a linguistic perspective, insofar as each language is an instrument of communication, there is no such thing as a word that cannot be translated, though we might speak of a word as being translatable or untranslatable in terms of the individual translator's ability. Yet given the widespread public adoption of various foreign words, it can be difficult to insist on the use of translated equivalents. A central question that thus arises is how to write such loan words correctly. For example, the Russian word *plitka* ("stove") is pronounced *peleeteg* or *pileeteg* by Mongolians, though it has not yet been clearly established how this word should be correctly written when used in Mongolian.